

## **Багшийн бүтээлийн сан хийх воркшоп**

**-Бие даан, идэвхитэйгээр суралцах багшийг дэмжих зорилготой**

### **багшийн сургалт семинарын загвар-**

Түлхүүр үг: Багшийн бүтээлийн сан, сургалт семинарын загвар, ELP, бүтээлийн сан хийх воркшоп

#### **Хураангуй**

Энэхүү өгүүлэл нь багш нарт зориулан зохион байгуулсан багшийн бүтээлийн сан хийх воркшопын тухай бөгөөд багш нарын сургалт семинарын загварын үйл явцын тухай өгүүлж, түүний ач холбогдол болон асуудлын тухай авч үзсэн өгүүлэл юм. Бие даан, тасралтгүй суралцахыг дэмжих аргад бүтээлийн сан байдаг ба сурган хүмүүжүүлэх туршлага, багш нарын сургалт семинарт оролцсон туршлагадаа тулгуурлан өөрийн ажилд дүн шинжилгээ хийх, тасралтгүй суралцах багшийг дэмжихийн тулд сонгосон зүйл нь бүтээлийн сан бөгөөд түүнийг хийх воркшоп зохион байгууллаа. Багш нарын сургалт семинарын загварыг боловсруулах үед бүх оролцогчдын япон хэлний багшийн “өнгөрсөн”, “одоо”, “ирээдүй”-г холбож чадахуйц бүтцийг бодолцсоноос гадна бүтээлийн сан хийж үзсэнээр түүнийг хэрэглэх тухай ойлголтыг гүнзгийрүүлэхэд анхаарлаа.

Сургалт семинарын дараа явуулсан асуултын судалгааны үр дүнгээс “бүтээлийн сангийн тухай ойлголт” болон “багшийн насан турш суралцахыг дэмжих” тал дээр оролцогчдоос эерэг үнэлгээ авсан боловч багшийн бүтээлийн санг цаашид ч үргэлжлүүлэн хэрэглэх арга болон багшийн бүтээлийн сан хийх туршлагыг бүх багш нар сургууль дээрээ ашиглахтай нь холбогдох тал дээр асуудалтай хэвээр үлдлээ.

#### **1. Эхлэл**

##### **1.1. Өгүүллийн бүтэц**

Энэхүү өгүүлэлд багш нарын сургалт семинарт оролцогчид өөрийн бүтээлийн санг хийх воркшоптой холбоотой сургалт семинарын загварын тухай өгүүлж, түүний ач холбогдол, асуудлын тухай авч үзлээ. Сургалт семинарыг зохион байгуулахтай холбогдуулан түүнийг зохион байгуулсан судлаач би “багшийн насан турш суралцахыг дэмжих” хэмээх тал болон “бүтээлийн сан хийх туршлага ба ойлголтыг гүнзгийрүүлэх” хэмээх талыг бодолцон загвар боловсруулсан билээ. Өөрөөр хэлбэл, багш нарын сургалт семинарт оролцогчид хичээл сургалтын ажлыг хэрэгжүүлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх тухай өмнөх туршлага болон өнөөгийн тулгарч буй асуудал, хүсч буй зүйлийн тухай эргэн дүгнэж, цаашдын зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөтэйгөө холбож чадахуйц зүйлийг хийгээсэй гэсэн үүднээс зохион байгуулсан билээ. Үүн дээр нэмээд бүх үйл ажиллагааны үр дүнг хамгийн сүүлд нь бүтээлийн санд нэгтгэснээр семинарт оролцогчид бүтээлийн сангийн бүтэц, тус тусын бүтэц

доторх хүчин зүйлүүдийн агуулга, утгыг дахин мэдэж авч, бүтээлийн сангийн тухай ойлголтоо улам сайжруулж чадахуйцаар загварчиллаа.

Мөн энэхүү өгүүлэлд ийм төрлийн сургалт семинар нь “багшийн насан турш суралцахыг дэмжих” болон “бүтээлийн сан хийх туршлага ба ойлголтыг гүйнзгийрүүлэх” хэмээх тал дээр ач холбогдолтой байсан эсэх тухай сургалт семинарын дараа явуулсан оролцогчдын асуултын судалгаанд дүн шинжилгээ хийж, сургалт семинарын үр дүнд үндэслэн түүнийг зохион байгуулахын ач холбогдол болон цаашдын асуудлыг авч үзлээ.

## **1.2.Багшийн бүтээлийн сан**

Сүүлийн жилүүдэд япон хэлний сургалтад ч бие даан тасралтгүй сурахыг дэмжих арга болон сурах үйл явцын үнэлгээ болгон бүтээлийн санг хэрэглэхийг зөвлөж байгаа бөгөөд хичээлдээ ашигласан тухай тайлангууд байдаг (Катагири 2014:8-9). Бүтээлийн сан гэвэл түүнийг хэрэглэдэг япон хэл суралцагчид юуны түрүүнд санаанд буух боловч суралцагчдад зориулсан бүтээлийн сангийн хэрэглээгээр зогсохгүй япон хэлний сургалттай холбоотой өгүүлүүдэд ч хэрэглэгддэг болсон байна (Кодама нар 2007, Мацүүра нар 2013).

Багшийн сургалттай холбоотой өгүүлүүдийн дотор өгүүлж буй багшид зориулсан бүтээлийн санд түүний хэрэглээнээс шалтгаалан дараах 2 зүйл байдаг. Багш өдөр тутмын сургалтын үйл ажиллагаагаа тэмдэглэх, сургалтын амжилтын тэмдэглэлээ нэгтгэсэн “Хичээлийн бүтээлийн сан” болон багш нарын семинарт оролцох үед хэрэглэх багш нарын сургалт семинарын бүтээлийн сан (цаашид сургалт семинарын бүтээлийн сан гэж нэрлэнэ) байдаг. Хичээлийн бүтээлийн сан нь багш хичээлээ хэрхэн явуулснаа дүгнэн хичээлээ сайжруулахын тулд хийхийн зэрэгцээ сургалтын үйл ажиллагаагаа үнэлэхийн тулд нотолгоо болох зүйл болгон ашиглаж байна. Нөгөө талаас сургалт семинарын бүтээлийн сан нь багш нарын сургалт семинарт оролцох үед оролцогчид болох багш нар суралцагчийн байр сууринаас сургалт семинарт сурсан зүйлээ эргэн дүгнэж, үр дүнг үнэлэх гэсэн үүднээс суралцагчдад зориулсан бүтээлийн сантай ойрхон гэж хэлж болно.

Энэхүү өгүүлэлд өгүүлэх багшид зориулсан бүтээлийн санд багшийн сурах хоёр зүйл болох “сургалт явуулахад анзаарсан зүйл болон өөртөө хийсэн дүн шинжилгээнээс сурсан зүйл”, “багш нарын сургалт семинараас сурсан зүйл”-ийг багтаалаа. Өөрөөр хэлбэл, хичээлийн бүтээлийн сангийн хүчин зүйл болон сургалт семинарын бүтээлийн сангийн хүчин зүйлийн аль алиныг авсан бөгөөд багш хэмээн бие даан суралцаж явах багшийн насан турш суралцахыг дэмжих бүтээлийн сан юм. Тиймээс энэхүү өгүүлэлд өгүүлэх бүтээлийн санг “багшийн бүтээлийн сан” гэж нэрлэн хичээлийн бүтээлийн сан, сургалт семинарын бүтээлийн сангаас ялгана.

Мөн багшийн бүтээлийн сангийн тайлан болох Мацүока нар (2013) Хятадын их сургуулийн багш нарт зориулсан сургалт семинартаа хэрэглэсэн

“Оролцогчид хичээл сургалтаа зохион байгуулах үйл ажиллагаагаа эргэн дүгнэж тэмдэглэсэн хичээлийн бүтээлийн санд багш нарын сургалт семинарын бүтээлийн санг оруулан нэгдсэн бүтээлийн сан” нэвтрүүлэхийг турших тухай өгүүлсэн байна.

Энэхүү өгүүлэл дэх багшийн бүтээлийн сан нь хичээл сургалтаа зохион байгуулах үйл ажиллагаагаа эргэн дүгнэх, багш нарын сургалт семинарын хичээл болон бүтээлийн сан хийх үйл ажиллагаагаар дамжуулан суралцагчдад зориулсан бүтээлийн сангийн ойлголтыг гүнзгийрүүлэх гэдэг тал дээр Мацүока нар (2013)-тай адил боловч сургалт семинарын хэлбэр нь өөр учраас бүх загвар нь өөр болох юм. Мацүока нар (2013)-ын зохион байгуулсан сургалт нь 2 сар хагас үргэлжилсэн тул бүтээлийн сангийн тухай лекц, сэтгэлзүй, хичээлийн бүтээлийн сан зэргийг хийсэн ба тэр нь өдөр тутмын хичээлийн үйл явцыг нь ч хамруулсан шатчилсан бүтээлийн сан хийхийг зорьсон сургалт семинарын загвар болсон байна.

Нөгөө талаас энэхүү өгүүлэлд өгүүлэх сургалт семинар нь 1 удаагийн сургалт семинар тул цагийн хувьд хязгаарлагдмал. Улмаар сургалт семинарын үйл явцаар дамжуулан шатчилсан бүтээлийн сан хийх биш, хичээл сургалтынхаа үйл ажиллагааг зохион байгуулах болон сургалт семинарт оролцохтой холбоотой тус тусын туршлагыг цэгцэлж, одоо хийж буй сургалт болон түүний асуудлыг нэгтгэн дүгнэж цаашдын төлөвлөгөөндөө оруулсаны дүнд бүтээлийн сан бэлэн болохоор загварчилсан билээ.

## **2. Багшийн бүтээлийн сан хийх воркшоп: загвар болон хэрэгжилт**

### **2.1. Сургалт семинарын бүтэц**

Энэхүү сургалт семинар нь Испанийн япон хэлний багш нарын холбоо, Мадридийн япон соёлын төвийн хамтран хийсэн сургалт бөгөөд 2014 оны 4-р сард зохион байгуулсан “Одоо, өнгөрсөн, ирээдүйн багш би сургалт семинарыг холбох багшийн бүтээлийн сан хийх воркшоп” гэдэг япон хэлний багш нарын сургалт семинар юм. Сургалт семинар нь 3 цаг хагас явагдаж, 23 хүн оролцов. Энэ улсад 2010 онд багш нарын холбоо байгуулагдсанаас хойш улсын хэмжээний сургалт семинарыг жилдээ 5-6 удаа зохион байгуулахаас гадна орон нутагт ч явуулдаг бөгөөд өнөөг хүртэл багшийн хөгжлийг сэдвээ болгосон сургалт болон бүтээлийн сангийн тухай сургалт явагдаж байгаагүй юм. Мөн сургалтад оролцогчид өмнө нь янз бүрийн багш нарын сургалтад оролцож байсан боловч өөрийн багшийн бүтээлийн сан хийх үйл ажиллагаа нь анх удаагийнх байлаа.

### **2.2. Сургалт семинарын загвар**

Сургалт семинарын загварыг зохион байгуулагчдаас “бодит бөгөөд хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт хийхийг хүсч байна” гэдэг хүсэлт ирсэн учир сургалтын хэлбэрийг лекц болон төрөл бүрийн үйл ажиллагааг

(ганцаарчилсан, хоёул, багийн ярилцлага) хийж хамгийн сүүлийн үр дүн болгон бүтээлийн сан хийх воркшоп хэлбэрийн сургалт байв.

### **2.2.1. Сургалт семинарын зорилго**


Энэхүү сургалт семинар нь дараах 2 зорилготой.

- 1) Өөрийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа, сургалт семинар зэрэгт оролцсон туршлага зэргийг эргэн дүгнэж өнөөгийн тулгарч буй асуудал, ирээдүйд хэрэгтэй зүйлүүдийг цэгцлэх
- 2) Багшийн бүтээлийн сан хийж үзсэнээр хэрэглэгч (сургалт авч буй өөрийн суралцагч)-ийн байр сууринаас бие даан суралцахыг дэмжихийн тулд бүтээлийн сан хэрэглэхийн ач холбогдол, хэрэглэх аргын тухай ойлголтоо гүнзгийрүүлэх
- 1) нь багшийн насан туршийн боловсрол хэмээх байр сууринаас тавьсан зорилго боловч Оказаки, Оказаки нар (1997) болон Ёкомизо (2005) нарын хэлсэн өөрийн хичээлд дүн шинжилгээ хийн хөгжих “Өөрийгөө хөгжүүлэгч багш”-ийг зорихтой холбоотой юм. Мөн Хаяши (2006) нь өөрийгөө хөгжүүлэгч багшийг зорихын тулд хичээлийг зохион байгуулах- ажиглах- шинэчлэх гэдэг эргэлтийг идэвхитэйгээр явуулахаар барахгүй, “өөрийн хичээлдээ тухайн үед нь өөрт хэрэгтэй зүйлээ харж, тохирсон сургалт семинарыг өөрөө сонгон оролцох хэрэгтэй” хэмээгээд “өөрөө сонгон шийдэх эрх” болон “хэрэгжүүлэх чадвар”-ыг “Өөрийгөө хөгжүүлэгч багш”-ийн хүчин зүйл болгож байна. Багшийн хөгжилтэй холбоотой хичээл сургалтыг явуулахаар барахгүй багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцох тухайд ч энэхүү сургалт семинарын зорилго оршиж байгаа юм.
- 2) нь мэдлэг болгон ойлгохоор зогсохгүй бүтээлийн санг хэрэглэгчийн байр сууринаас хийж үзсэнээр бүтээлийн сангийн ойлголтоо гүнзгийрүүлж, үр дүнтэй хэрэглэхийг зорьсон зүйл юм. Мацүока нар (2013) нь багш сургалт семинарын бүтээлийн санг хийснээр сурах бүтээлийн сангийн онцлогыг ойлгох гэдэг зорилгыг хэрэгжүүлж чадна гэж хэлж байгаа боловч хичээл сургалтын ажлаа зохион байгуулахад суралцагчдад хэрэглүүлэх гэдэг байр сууринаас салж, хэрэглэгчийн байр сууринаас бүтээлийн санг хэрэглэснээр өнөөг хүртэл хэрэглэж ирсэнээс өөрөөр бүтээлийн санг ойлгоно гэж найдаж байна.

### **2.2.2. Сургалт семинарын агуулга ба бүтэц**

Дараа нь сургалт семинарын агуулга ба бүтцийн тухай өгүүлье. 2.2.1-д өгүүлсэнчлэн сургалтад оролцогчид “өөрийн сургалтын үйл ажиллагааг явуулах, сургалт семинарт оролцсон туршлагаа дүгнэнгээ өнөөгийн тулгамдаж буй асуудал болон цаашид хэрэгтэй зүйлийг цэгцлэх” –ийг зорилгын нэг болгосон билээ.

Энд сургалт семинарын бүтцийг “өнгөрсөн, одоо, ирээдүй” гэдэг цагийг ашигласан хэсгүүдэд хувааж (зураг 1), тэрхүү 3 хэсгээр дамжуулан сургалтад оролцогч нь өөрийн хичээл сургалтын үйл ажиллагаа, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт болон төсөл зэрэгт оролцсон туршлагаа эргэн дүгнэж одоо тулгамдаж буй асуудлыг дэвшүүлэн дүн шинжилгээ хийж, цаашдын идэвхитэй үйл ажиллагаагаа бодож чадахаар загвар гаргалаа. Гэхдээ тус тусын хэсгүүд нь эргэн дүгнэлт хийх үйл ажиллагааг асуудалгүй явуулах нь бүх оролцогчдын хувьд амьдралд ойр зүйл гэж үзээд “одоо”-гийн хэсгээс эхлэн “өнгөрсөн”, “ирээдүй” гэж явуулахаар төлөвлөв.



Зураг 1. Сургалт семинарын бүтэц

Сургалт семинарт нийт 14 үйл ажиллагаа хийсэн ба тус тусын үйл ажиллагаагаар тараах хуудаст бичүүлэх зэрэг “бүтээл”-ийг хийлгэж, хамгийн сүүлд нь түүнийг багшийн бүтээлийн сан болгон нэгтгэж байв. Мөн бүх үйл ажиллагаа нь үйл ажиллагаа 5) 6) шиг одоо сонирхож байгаа сэдэв болон багшийн хувьд өөрийнхөө онцлогийг мэдрэх, үйл ажиллагаа 8) 9) шиг өмнө оролцож байсан сургалт семинараа жагсаан бичиж өөрийнх нь хувьд ямар ач холбогдолтой байсан зэрэг өөрийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа болон сургалт семинарт оролцсон туршлагыг эргэн дүгнэж, өнөөгийн тулгарч буй асуудал, ирээдүйд хэрэгтэй зүйлээ цэгцлэх боломжтой болгохоор загварчиллаа.

Дараа нь сургалт семинарын 2 дахь зорилго болох бүтээлийн сангийн тухай ойлголтоо гүнзгийрүүлэх, сургалт семинарын загварын холбооны тухай


өгүүлье. Энэхүү сургалт семинарт бүтээлийн сан хийснээр түүний тухай ойлголтоо гүнзгийрүүлж, сургалтдаа ч идэвхитэйгээр хэрэглэхийг зорьсон юм. Үүнд сургалт семинарын загварыг боловсруулахтай холбогдуулан Европын хэлний сургалтад тулгуурлан боловсруулсан “Европын холбооны улсуудын олон хэлний суурь хөтөлбөр (Common European Framework of Reference for Languages, цаашид CEFR гэнэ)”-ийн ухагдахууныг загвар болгосон “Европын хэлний бүтээлийн сан (European Language Portfolio, цаашид ELP гэнэ)” –д тулгуурлан багшийн бүтээлийн сангийн загварыг гаргасан. Бодитоор хэлбэл, сургалт семинарын бүтээлийн сангийн тус тусын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэх үед ELP-ийн 3 хүчин зүйл болох “Хэлний паспорт” (Language Passport) “Хэлний намтар” (Language Biography) ”Материалууд”(Dossier)-тэй холбоход анхаарав (хүснэгт 1).

**Хүснэгт 1. ELP ба энэхүү сургалт семинарын багшийн бүтээлийн сангийн харьцуулалт**

<b>Европын хэлний бүтээлийн сан (European Language Portfolio)</b>	<b>Энэхүү сургалт семинарын багшийн бүтээлийн сан</b>
Хэлний паспорт (Language Passport)	Паспорт Passport/Passaporte
Хэлний чадвар, хэл сурах туршлага, өөр соёлын туршлагыг цэгцэлсэн зүйл бөгөөд тэдгээрийг ойлгомжтой нягталж чадах паспорт.	Оролцогчид өөрөө ямар япон хэлний багш вэ? гэдгээ илэрхийлэхийн тулд ашиглаж чадах намтар
Хэлний намтар” (Language Biography) (Хэл сурах тэмдэглэлийн дэвтэр )	Biography/Biographia (Сургалт явуулах, сургалт семинарт оролцсон туршлагын тэмдэглэл)
Сурах зорилгоо тодорхойлж, өөрийн сурах үйл явцаа ажиглах, хэл сурах, өөр соёлын туршлагыг бичиж явах хэсэг. Өөрийн сурах төлөвлөгөөг гаргах, үйл явцыг ажиглах, өөрийн үнэлгээ, дүн шинжилгээ зэргийг явуулахад туслах өдрийн тэмдэглэлтэй адил зүйл.	Оролцогчид өнөөг хүртэлх зааж ирсэн туршлага, сургалт семинарт оролцсон тэмдэглэлээ цэгцэлж, нэгтгэсэн зүйл болон бүтээлч багшийн хувьд цаашид оролцмоор байгаа сургалт семинар, төсөл зэргээ бичсэн зүйл. Эргэн дүгнэх болон цаашдын үйл ажиллагаатай холбогдох зүйл.
Материалууд (Dossier)	Dossier (Материалууд)
Хэрэглэгч нь өөрийн хэл сурах эцсийн түвшинг тодорхойлоход хэрэгтэй гэж бодсон зүйл болон хэл, соёл сурах түвшин, туршлага зэрэг тэмдэглэлийг өөрөө сонгон хадгалах хэсэг.	Энэхүү сургалт семинараар сурсан зүйл болон түүний үр дүн. Passport, Biography-тай холбоотой үйл ажиллагааны материалууд.

Түүнчлэн эдгээрийн холбоог тодорхой болгож чадахуйц үйл ажиллагаа бүрийн тараах хуудас, бүтээл зэрэгт ELP-ийн 3 хүчин зүйлийн эхний үсгийн товчлолыг илэрхийлсэн [P], [B], [D] гэдэг тэмдэглэгээ болон дугаар зэргийг эхлээд тавьж зураг 2-т илэрхийлсэн ёсоор үйл ажиллагаа 11) –т хийсэн тараах хуудас, бүтээлийг [P], [B], [D]-ээр дахин ангилбал ELP-тэй адил хүчин зүйлээр

нэг бүтээлийн санг бүрдүүлнэ. Бүтээлийн сан хийсний дараа үйл ажиллагаа 12)-т сургалтаар хийсэн зүйлээ хамруулаад төрсөн сэтгэгдлээ “сайн тал” болон “хэцүү ба асуудалтай тал” гэж ангилан бичсэнээр, бүтээлийн сан ашиглах ач холбогдол, асуудлын тухай дахин магадлах боломжтой болсон.



Зураг 2. Сургалт семинарын бүтцийн ерөнхий зураглал

Энэ нь сургалт семинарт оролцогчид бүтээлийн санг хэрэглэгчийн байр сууринаас ашиглах тухайд ажигласан зүйл бөгөөд сургалт семинарын зорилго 2) “Багшийн бүтээлийн сан хийснээр хэрэглэгч (суралцагч)-ийн байр сууринаас бие даан суралцахыг дэмжихийн тулд хийх бүтээлийн сан хэрэглэх ач холбогдол, хэрэглэх аргын тухай ойлголтоо гүнзгийрүүлэх”-тэй холбогдох юм.

### 3. Багшийн бүтээлийн сан хийх воркшопын ач холбогдол ба асуудал


Сургалт семинарын дараа явуулсан анкетийн судалгаанд дүн шинжилгээ хийж, багшийн бүтээлийн сан хийх воркшопын ач холбогдол ба асуудлын тухай бодно. Асуултын хуудсыг тараасан тоо, хариултын тоо аль аль нь 22 ширхэг байлаа. Асуултын хуудас 10 асуулттай ба 5 аргаар сонгосон шалтгааныг бичүүлэх асуулт болон чөлөөтэй бичиж хариулах хариултаас бүтсэн. Мөн асуулт нь сургалт семинарын сэтгэл ханамж зэрэг сургалт семинарыг бүхэлд нь хамарсан асуулттай ба энэхүү өгүүлэлд багшийн бүтээлийн сан хийх хэмээх сургалт семинарын загварын ач холбогдол болон асуудалтай талын тухай судлахын тулд ялангуяа “эргэн дүн шинжилгээ хийснээр өнөөгийн тулгарч буй асуудал болон цаашдын үйл ажиллагааг төлөвлөх”, “бүтээлийн сангийн ойлголтыг гүнзгийрүүлэх” гэсэн 2 зүйлийг авч анкетийн судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийв. Тодруулбал дараах 4 асуулт юм.

- (1) Багшийн бүтээлийн сан хийх үйл ажиллагаа нь бүтээлийн сангийн тухай ойлгоход хэрэг болсон уу? [сонгох+шалтгаан]
- (2) Цаашид ч багшийн бүтээлийн санг хэрэглэмээр байна уу? [сонгох+шалтгаан]
- (3) Багшийн бүтээлийн санг хийхэд ямар сэтгэгдэл төрсөн бэ? [чөлөөт хариулт]
- (4) Сайн ойлгоогүй зүйл, илүү их мэдмээр байгаа зүйл [чөлөөт хариулт]


### 3.1. Асуулт бүрийн хариултад хийсэн дүн шинжилгээ

#### 3.1.1. (1) Багшийн бүтээлийн сан хийх үйл ажиллагаа нь бүтээлийн сангийн тухай ойлгоход хэрэгтэй байсан уу?

“Маш хэрэгтэй байсан” шалтгаан нь “Бодитоор хийж үзээд сайн ойлгосон”, “Бодитоор хийж үзэхэд сайн мэдэж авах зүйл их байсан. Ялангуяа бүтээлийн сан нь өнөөг хүртэл хичнээн сонссон ч сайн ойлгодоггүй зүйл байсан учраас”, “(хийх) бүхий л үе шат, бүхий л үйл ажиллагаа сонирхолтой учраас маш их хэрэг болсон” зэргийг бичсэн байсан ба “(бүтээлийн сан хийх) бодит туршлага” нь “хэрэг болсон” гэсэн үнэлгээтэй холбогдож байна гэж үзэж байна. Энэхүү сургалт семинараар багшийн өнгөрсөн туршлага, одоогийн байдлыг эргэн дүгнэсэн үйл ажиллагаа болон цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай бодох үйл ажиллагаа явуулангаа, хамгийн сүүлд ELP-ийн бүтцийг тусгасан “Паспорт”, “Сургалтын ажил болон сургалт семинарт оролцсон туршлагын тэмдэглэл”, “Материалууд” гэсэн 3 хүчин зүйлийг нэгтгээд багшийн бүтээлийн санг бүрдүүлсэн боловч сургалт семинарт оролцогчид бодитоор бүтээлийн сан хийх үйл ажиллагаа хийснээр бүтээлийн сангийн бүтэц, тэмдэглэн хийх зүйлийн тухай илүү ойлголттой болсон гэж үзэж байна.



Зураг 3. Бүтээлийн сан хийх үйл ажиллагаа бүтээлийн сангийн ойлголтод үзүүлэх нөлөөний тухай бодол (Багшийн бүтээлийн сан хийх үйл ажиллагаа нь бүтээлийн сангийн тухай ойлгоход хэрэг болсон уу?)



Зураг 4. Бүтээлийн санг үргэлжлүүлэн хэрэглэхтэй холбоотой бодол (Цаашид ч багшийн бүтээлийн санг хэрэглэмээр байна уу?)



### **3.1.2. (2) Цаашид багшийн бүтээлийн санг хэрэглэмээр байна уу?**

“Яг тийм”, “Тийм” хариулт ихэнх хувийг эзэлж байсан боловч асуулт (1)-д “Маш их хэрэг болсон” хариулт хамгийн их байсан бол асуулт (2)-т “Яг тийм” биш, “Тийм” хариултын эзлэх хувь их болж байна (зураг 4). “Тийм” хариултын шалтгаан нь “Хэцүү боловч хийж үзмээр байна”, “Тийм боловч үргэлжлүүлэн хийх нь хэцүү гэж бодож байна. Гэхдээ жоохон ч гэсэн хийж үзье гэж бодож байна” гэсэн байв. Сургалт семинарт оролцогчдоос 11 хүн асуулт (1) –т “Маш их хэрэг болсон” гэж хариулж байсан бол асуулт (2)-ын бүтээлийн санг цаашид үргэлжлүүлэн хийх хүсэл сонирхлын тухай асуултад “Яг тийм” биш “Тийм” гэсэн хариулт л байснаас үзвэл хийж үзмээр байна гэсэн идэвхи болоод үргэлжлүүлэн хийж чадах уу гэдэг санаа зовнил графикаар гарч ирсэн гэж хэлж болно.

### **3.1.3. (3) Багшийн бүтээлийн санг хийхэд ямар сэтгэгдэл төрсөн бэ?**

Чөлөөт хариултад хариулсан тоо 12 байсан бөгөөд ерөнхийд нь хуваавал “Бүтээлийн сангийн ойлголт”-той холбоотой зүйл болон “Сургалтын ажлын болон сургалт семинарт оролцсон туршлага зэргийн дүгнэлт ба анзаарсан зүйл”-тэй холбоотой зүйлүүд байлаа.

Бүтээлийн сангийн ойлголттой холбоотой зүйлүүдэд “(бүтээлийн санг) огт ойлгодоггүй байсан бол бага зэрэг ойлгодог болсон”, “дахин харахаар барахгүй ирээдүйтэй холбогдох чухал зүйл гэж бодсон”, “ач холбогдол, хэрэгцээний тухай ойлгосон боловч дахин үргэлжлүүлэн хийхийн тулд дахин бодох хэрэгтэй санагдлаа”, “өөрийн тэмдэглэгээ гэж бодсон боловч бусадтай хуваалцах зорилго агуулагдаж байгаа нь сонирхолтой байлаа”, “оюутны нүдээр бүтээлийн санг харж чадлаа” гэсэн хариултауд байсан ба бүтээлийн санг өөрөөр харж чаддаг болж үзэл бодол нь гүнзгийрсэн гэдэг нь ажиглагдлаа.

Мөн сургалтын ажлын болон сургалт семинарт оролцсон туршлагаа дүгнэх болон анзаарсан зүйлтэй холбогдох зүйл нь “сургалт семинар зэрэгт олон оролцсон боловч түүнийг ач холбогдолтой ашиглаж байснаа мэдэрсэн”, “өөрөө өнөөг хүртэл хийж ирсэн зүйлээ эргэн дүгнэвэл цэгүүд нь шугамаар холбогдсон санагдаж байна”, “өнөөг хүртэлх багш хэмээх байр суурь, одоогийн багшийн бодол, цаашид зорьж буй зүйл нь энэхүү бүтээлийн санд агуулагдаж байгаа санагдсан” гэдэг хариулт байлаа. Бүтээлийн санг дүгнэхийн тулд тус тус дүгнэлт хийх үйл ажиллагаануудыг энэхүү сургалт семинарын сэдвээр илэрхийлж чадахуйц “Өнгөрсөн- одоо- ирээдүйн багш би”-г эргэн харсан гэж хэлж болох юм.

### **3.1.4. (4) Ойлгоогүй зүйл, илүү их мэдмээр байгаа зүйл**

Чөлөөт хариултын 7 асуулт байсан ба “Хичээлдээ бодитоор хэрэглэх арга”, “Оюутнууд бүтээлийн сангаа үр дүнтэй ашиглах арга”, “Оюутны

бүтээлийн сан ба багшийн бүтээлийн сангийн ялгаа”, “Жинхэнэ бүтээлийн сан хийх” зэргийг бичсэн байлаа. Сургалт семинарт оролцогчдын дотор багшийн бүтээлийн сан хийж үзсэн боловч сургалт семинарын үйл ажиллагаа болон воркшопын үйл ажиллагаа, япон хэлний сургалтад хэрэглэхээ холбож өгөх нь хэцүү, оюутны бүтээлийн санг жинхэнээр хичээлийн үйл ажиллагаандаа хэрхэн хийх тухай асуудалтай хэвээр хоцорсон байх талтай.

### **3.2.Багшийн бүтээлийн сан хийх воркшопын ач холбогдол**

Энэхүү сургалт семинарын ач холбогдлыг дараах 2 зүйлээр дүгнэж болно.

Нэгдүгээрт, “Бүтээлийн сангийн тухай ойлголт” юм. 3.1.1. болон 3.1.3.-аас багшийн бүтээлийн сан хийх үйл ажиллагааг хийснээр сургалт семинарт оролцогчдын бүтээлийн сангийн үүргийг (бүтээлийн сан хийхийг сурсан туршлагаа тэмдэглэж, эргэн дүгнэлт хийн, бие даан суралцахын тулд хэрэглэх арга) дахин нягталж, үргэлжлүүлэн хийхийн тулд ямар арга сэдэж хэрэглэх тухай харж чаддаг болсон. Мөн тэрхүү шинээр олж харсан зүйл нь бүтээлийн сан хийхийн утга учир болон хэрэглэх гол зүйл зэрэг бүтээлийн сантай холбоотой ойлголтоо нэмэгдүүлэхтэй холбогдоно гэж үзэж байна.

Хоёрдугаарт, “Багшийн насан туршийн боловсролыг дэмжих” тал юм. Энэхүү сургалт семинарт “одоо” “өнгөрсөн” “ирээдүй” гэдэг талаас өнөөг хүртэлх багшлах үйл ажиллагааны туршлага, оролцож ирсэн сургалтуудаас олж авсан мэдлэгийг эргэн дүгнэж, багшийн бүтээлийн сан боловсруулах үйл ажиллагаа хийсэн ба тэрхүү үйл ажиллагааг хийснээр насан туршид суралцах гэдэг тухай ойлгох боломж гарсан гэж үзэж байна. Хилийн чанадад явагддаг багш нарын сургалт семинарын ихэнх нь хэдэн цагаас хэдэн өдрийн хугацаатай байх нь их, сургалт бүрийн сэдэв нь өөр байдаг. Мөн сургалт семинартаа эргэн дүгнэлт хийх цаг байдаггүй тохиолдол ч их бөгөөд сургалт семинарт бүрт бүтээлийн сан хийх нь ховор. Улмаар сургалт семинарт оролцогчид (багш нар) хичнээн олон сургалтад оролцсон ч тэдгээрийн холбоо болон сургалтаас сурч авах зүйл, хичээл сургалтын ажлыг бодитоор явуулах холбоо хамаарлын тухай боддоггүй, бодитоор төлөвлөгдөөгүй байх нь их байдаг. Мөн өдөр тутмын үйл ажиллагааны дотор тус тус сургалтаар олж авсан зүйлээ өөрийн болгож, багш хүний хувьд өсч хөгжих тухай бодох цаг гаргах нь ч бэрхшээлтэй. Тиймээс энэ удаагийн сургалт семинарт шиг бүтээлийн сан хийхийг зорилгоо болгон сургалт семинарын явцад өмнө оролцож байсан хэд хэдэн удаагийн сургалт семинараа багш нар тус бүртээ дүгнэж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэх гэдэг талаас дүгнэн бодож чадах боломжтой болсон нь багшийг дэмжих гэдэг үүднээс үр дүнтэй арга болсон гэж хэлж болно.

### **3.3. Багшийн бүтээлийн сан хийх воркшопын асуудал**

Нөгөөтэйгүүр, мэдээж шийдээгүй асуудлууд ч гарч байна. Энэ удаагийн сургалт семинар нь багшийн бүтээлийн сан хийх хэмээх эцсийн зорилготой байсан учраас бүтээлийн сантай холбоотой ойлголтоо гүнзгийрүүлж чадсан ч анкетийн судалгааны үр дүнгээс дараах 2 асуудал харагдлаа.

Нэгдүгээрт, боловсролын байгууллага дахь суралцагчдын бүтээлийн сангийн хэрэглээ юм. Энэ удаа хийсэн нь багшийн бүтээлийн сан байсан учраас дараа япон хэлний багшийн байр сууринаас суралцагчдаар бүтээлийн санг хэрхэн хийлгэх, ашиглах үеийн тодорхой аргуудаас сурмаар байна гэдэг хэрэгцээ байлаа. Багшийн бүтээлийн сан хийх нь бүтээлийн сан хийх тал болох “суралцагч (сургалт семинарт оролцогч)-ийн байр суурь”-иас бүтээлийн сан ашиглах байсан боловч түүнийг тус тус япон хэлний сургалтад япон хэл суралцагчдад бүтээлийн санг үр дүнтэй ашиглаж чадахуйц тусалж өгөх “багшийн байр суурь”-иас харахын тулд дахин нэг шатны дэмжлэг хэрэгтэй болно. Багшийн бүтээлийн сан хийх үйл явцыг хамруулаад япон хэл суралцагчдын бүтээлийн сан хэрэглээний тухай дахин бодож үзэх шаардлага гарч байна.

Хоёрдугаарт, 3.1.2.-оос цаашид ч үргэжлүүлэн багшийн бүтээлийн сан хиймээр байгаа нь харагдсан бөгөөд үнэхээр хэрэгжүүлж чадах эсэхийн тухайд өнөөгийн байдлаар хэлж мэдэхгүй байна. Энэхүү сургалт семинар нь 3 цаг хагас бүтээлийн сан хийхэд зориулагдсан ба тус тусын үйл ажиллагаанууд нь ч бусад оролцогчидтой хамт эргэн дүгнэж үр дүнгээ хуваалцахаар хийсэн. Гэвч энэ цаг болон бусадтай хуваалцах тал нь сургалт семинарын дараах өдрүүдийн өдөр тутмын сургалтын орчноос өөр тул сургалт семинараар явуулсан үйл ажиллагааг түүний дараа ч сургалтандаа ашиглах нь амар биш юм. Улмаар сургалт семинарыг зохион байгуулагчид түүний дараа сургалт семинарт оролцох үедээ багшийн бүтээлийн сан үргэлжлүүлэн хийх боломж олгох, оролцогчдын хүсэлтээр цуглаж, тогтсон хугацаанд багшийн бүтээлийн сангаа шинэчилж явах боломж олгохоор зохион байгуулах хэрэгтэй гэж бодож байна.

### **4. Дүгнэлт**

Энэ удаагийн сургалт семинараар бие даан, идэвхитэйгээр суралцах багшийг дэмжих хэмээх байр сууринаас өөрийн сургалтын үйл ажиллагаа болон сургалт семинарт оролцсон туршлага зэргээ эргэн дүгнэж багшийн хувьд суралцах боломжийг олгох хэрэгсэл болгосон багшийн бүтээлийн сан хийх воркшоп юм.

Сургалтын үйл ажиллагаагаа эргэн дүгнэж түүнээ бусадтай хуваалцах боломж багшлах дадлага хөтөлбөр болон дөнгөж зааж эхэлж байх үед л идэвхитэйгээр хийгддэг боловч заах туршлага хуримтлагдан, өөрийн заах арга барил, итгэл үнэмшил төлөвшихөд багшлах үйл ажиллагаагаа эргэн

харах, ялангуяа түнийг бусадтай хуваалцах боломж багасдаг. Ийм нөхцөл байдалд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтаар шинэ мэдлэг, мэдээлэл олохоор барахгүй, өөрийн сургалтын үйл ажиллагаагаа эргэн дүгнэх гэдэг утгаараа чухал ач холбогдолтой юм. Гэвч тэдгээр сургалт семинар дахь сургалт нь тэмдэглэн үлдээх зүйл бага, сургалтын дараа ч тэр хэвээр хоцорч багшийн хөгжилтэй холбогдон эргэн дүгнэх боломж, сургууль дахь сургалтын үйл ажиллагаанд бодитоор хэрэгжүүлэх зэрэгт бэрхшээлтэй байдаг.

Энэхүү сургалт семинараар багшийн бүтээлийн санг багшийн хөгжиж боловсрохыг дэмжих аргын нэг гэж үзэн, багшийн сургалтын үйл ажиллагааны туршлага, сургалт семинарт оролцогчийн хувьд суралцах туршлагаа тэмдэглэн, нэгтгэн дүгнэх зүйл гэж тодорхойлсон. Мөн сургалт семинарын бүтээлийн сан хийх туршлага нь бүтээлийн сангийн тухай ойлголтыг гүнзгийрүүлэхтэй холбогдохоор хийлээ. Тодруулан хэлбэл, сургалт семинарыг загварчлахдаа эргэн дүгнэх цаг их гаргаж, өнгөрсөн, одоо, ирээдүйг нэг шугам болгон багшийн үйл ажиллагаагаа дүгнэж цаашид тасралтгүй суралцах багш байх шаардлага хэрэгцээний тухай бодуулахыг шугаман дээр хийлгэлээ. Мөн бүхий л үйл ажиллагаагаар хийсэн материалаа дахин харахын хамт хамгийн сүүлд нь ELP-ийн бүтцийг тусгасан бүтээлийн сан болгож нэгтгэхэд анхаарч тэрхүү туршлагаа ELP-ийн бүтцийн хүчин зүйл нь ямар зүйл байдаг, ямар ач холбогдолтой болохыг илүү ойлгуулахын тулд анхаарлаа.

Сургалтад оролцогчдын саналаас сургалт семинарыг загварчилсан зохион байгуулагчдын санааг бүрэн ойлгосон нь харагдаж байлаа. Гэвч бүтээлийн сан нь цаашид суралцахыг дэмжих арга бөгөөд нэг удаа хийвэл дуусдаг зүйл биш юм. Энэ удаагийн воркшоп нь зөвхөн эхлэл болсон учраас хийсэн бүтээлийн сангаа цаашид үргэлжлүүлэн хийх нь хамгийн том асуудал юм. Цаашид бичиж тэмдэглэх болон цэгцлэхэд болон эргэн дүгнэхэд амар хялбар харагдахуйц е бүтээлийн сангийн хэлбэрээр хийх, багшийн сургалт семинар зэрэг боломжуудыг ашиглан бусад багш нартай хамт эргэн дүгнэх боломж бүрдүүлэх зэргээр арга боловсруулах хэрэгтэй гэж үзэж байна.

Мөн энэ удаагийн сургалт семинар нь багшийн бүтээлийн сан боловсруулах воркшоп байсан бөгөөд тэрхүү хийсэн туршлагаараа дамжуулан олж авсан мэдлэг, сэтгэгдэлээ ашиглан суралцахуйн бүтээлийн сантай хэрхэн холбох нь дараагийн асуудал болж байна. Сургалт семинарт оролцогчдын мэдэрсэн туршлага, багшийн бүтээлийн сангаа бүхий л сургалтын байгууллагад хэрхэн ашиглах, суралцагчдын байр суурь болон багшийн байр суурийг нэгтгэж үзье гэж бодож байна.

Хавсралт

		Үйл ажиллагаа	Зорилго	Үйл ажиллагааны агуулга, хэлбэр	Бүтээл
1	Сургалт семинарын бүтэц, сэдэлжүүлэлт	Сургалт семинарын бүтэц, агуулгын тайлбар	Сургалт семинарын зорилго, хүрэх үр дүн, явцыг ойлгох		
		Оюуны зураглал (ММР) хийх [Before]	Сургалт семинарын “орох хаалга”-ыг гаргах	(1) “Бүтээлийн сан”-гийн түлхүүр үгсээр оюуны зураглал хийх [хувь хүн]	D1 ММР Before
2	Өнөө	Би бол ийм багш	Өөрөө ямар багш вэ? өөрийгөө харах	(2) Багшийн илэрхийлэх үг хэллэгийг 2,2-оороо баг болж гаргах ба дараа нь бусад багтай хуваалцана. Тэдгээр үг хэллэгийг ашиглан өөрөө оюутны зүгээс ямар харагдаж байгаага төсөөлөн цаасан дээр бичнэ. [хоёул→баг→хувь хүн→нийт] (3) (2)-т хийснээ ашиглан ямар багш болохыг зорьж байгаага бичиж, бусадтай хуваалцана. [хувь хүн→баг] (4) Багшийн намтар хийнэ.	D3 Зорьж буй багшийн зураглал P1 намтар
		Заах аргатай холбоотой жагсаалт	Багш би (сайн чаддаг зүйл, чаддаггүй зүйл)-гээ бодно.	(5) Жагсаалтыг бөглөж, бусад оролцогчидтой хуваалцан, харьцуулна. [хувь хүн→баг]	B1 Жагсаалт
		Өнөөгийн асуудал ба сонирхол	Багш болох миний сонирхол, асуудлаа бодно.	(6) Одоогийн сонирхож буй зүйл, бодогдож буй асуудлаа нэг нэгээр нь бичиж явна. Дараа нь А.Өөрөө шийдэж чадах асуудал, В.Бусадтай хамтрах шаардлагатай зүйл, С.Өөрийн хүчээр шийдэж чадахгүй асуудал гэж ангилж, хоёр хоёроороо ярилцана. Мөн ярилцагчийнхаа яриаг сонсон хамгийн таалагдсан зүйлээс нэгийг сонгож, бусдад ч ойлгогдох үг хэллэгээр нэгтгэн хамтрагчдаа өгнө.	P2 Миний сонирхол ба асуудал

3	Өнгөрсөн	Багш болох хүртэлх болон багш болсноос хойшхи үеэ эргэн дүгнэнэ	Багш, суралцагч би-гээ эргэн дүгнэнэ.	(7) Япон хэлний багшийн үүднээс өнөөг хүртэлх туршлага, ялангуяа сэтгэлд хоногшсон зүйлээ нэг хүснэгтэд бичнэ. Мөн гадаад хэл суралцагчийн хувьд сайн байсан болон сайн биш байсан туршлагаа эргэн дүгнэж хүснэгтэд бичнэ. Дараа нь хоёул ярилцана. [хувь хүн→хоёул]	<b>B2</b> Багшийн туршлага, суралцагчийн туршлага
		Сургалт семинарын хэлбэрийг дүгнэх	Сургалт семинарын хэлбэрийг цэгцлэх	<b>Aч холбогдол</b> Сургалт семинарын ангилал	
		Өмнө оролцсон сургалт семинарын жагсаалт	Өмнө оролцсон сургалт семинар(багшийн хувьд суралцсан туршлага)-аа эргэн дүгнэх	(8) Өнөөг хүртэл оролцож ирсэн сургалт семинарын жагсаалтыг нэгтгэх (өмнөх асуудал), сургалт семинарын хэлбэрийг бичих. [хувь хүн]	<b>B3</b> Өмнө оролцсон сургалт семинарын жагсаалт
		Сайн болсон, хэрэг болсон сургалт семинар	Миний хувьд сургалт семинарын ач холбогдол	(9) Сургалт семинарын жагсаалтыг харж, сайн болсон, хэрэг болсон сургалт семинарыг тэмдэглэн, түүний шалтгааныг ч бодно. Дараа нь бусад хүмүүст тайлбарлаж өгнө. [хувь хүн→хоёул, баг]	<b>B4</b> Сайн болсон, хэрэг болсон сургалт семинар
4	Ирээдүй	Хөгжихийн тулд би	Одоо болон өнгөрсөнд хийсэн дүн шинжилгээ ирээдүйтэй хэрхэн холбогдохыг ойлгох	<b>Aч холбогдол</b> Үйл ажиллагааны төлөвлөгөө	
		Семинар, сургалт, төслийг бодох	Өнөөгийн байдал, өнгөрсөн туршлагад дүн шинжилгээ хийж, багш бидний хөгжилд хэрэгтэй зүйлийг бодно.	(10) (6) (7)-ийн үйл ажиллагаагаар хийсэн материалдаа тулгуурлан баг болж семинар, төслийн тухай бодно. [баг→нийтээр]	<b>B5</b> Семинар, төслийн төлөвлөгөө
5	Бүтээлийн сангаа дахин бодох	Багшийн бүтээлийн сан хийх	Материалаа бүтээлийн сангийн хэлбэрээр нэгтгэх үйл	(11) Сургалт семинараар хийсэн материалаа P (Passport), B (Biography), D (Dossier)-т нэгтгэж, цаас наан бүтээлийн	

			ажиллагаагаар дамжуулан бүтээлийн сан хийх	сангаа хийж дуусгана. [хувь хүн]	
		Бүтээлийн санг ашиглах	Багшийн бүтээлийн сан хийх туршлагаас бүтээлийн сан хэрэглэх боломжийг бодно.	(12)Бүтээлийн сан хийсэн сэтгэгдэлээ сайн тал, бэрхшээлтэй тал, асуудал гэсэн хэсэгт хуваан хуудсанд бичиж, дараа нь бусадтай хуваалцана. [хувь хүн→нийтээр]	
		Яагаад багшийн бүтээлийн сан бэ?	Багшийн хөгжилд багшийн бүтээлийн сангийн ач холбогдлын тухай бодно.	Ач холбогдол Дүгнэлтээ хэрэгжүүлэх, суралцах туршлагын онол	
6	Дүгнэлт	Бүтээлийн сангийн тухай оюуны зураглал хийх [After]	Сургалт семинарын “орох хаалга” ба “гарах хаалга”-ыг харьцуулснаар сургалт семинараар сурсан зүйлээ бодно.	(13)”Бүтээлийн сан”-гийн түлхүүр үгээр оюуны зураглал хийж, (1)-ийн үйл ажиллагаагаар хийсэн зүйл (MMP [Before] )-той харьцуулна. Өөрчлөлтийн тухайд хүмүүстэй ярилцана. [хувь хүн→хоёул, баг]	D2 MMP After
		3 түлхүүр үг	Өнөөдрийн сургалт семинартай холбоотой өөрийн хувьд ач холбогдолтой болсон тухай бодно.	(14) 3 түлхүүр үгийг бодож, бусад хүмүүстэй хуваалцана. [хувь хүн→нийтээр]	D4 3 түлхүүр үг